



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2012 оны 05 сарын 03 өдөр

Дугаар 09/04

Эрдэнэт

**Төлөөлөн удирдах зөвлөл
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.4 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ НЬ:

1.Орон нутгийн өмчит “Жаргалант ус, дулаан түгээх станц” ОНӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг БОЛГОХ нь:


2.1.Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмыг боловсруулан батлуулах;

2.2.Гүйцэтгэх захирлын эрх, хэм хэмжээг дүрэм, ажлын байрны тодорхойлолтод нарийвчлан тусгаж, зарцуулах зардлын дээд хязгаар, өмч хөрөнгө, санхүүгийн нөөцийн эрхийг тогтоон хяналт тавин ажиллах;

2.3.Байгууллагын зорилтот түвшний хэрэгжилт, үйлдвэрлэлийн эдийн засгийн үр ашиг, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар дээшлүүлэх, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтыг сайжруулах, өр авлагагүй ажиллах талаар гүйцэтгэх захирлын хийж гүйцэтгэсэн ажлын тайланг хагас, бүтэн жилээр Орон нутгийн өмчийн газарт хүргүүлж байх;

3.Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавьж, төлөөлөл хэрэгжүүлсэн байдлын талаарх тайланг жил бүрийн 11 дүгээр сард багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж байхыг Орон нутгийн өмчийн газар (Л.Оюунгэрэл)-д даалгасугай.

ДАРГА




Д. МӨНХБАТ

C:\My documents\togtool

079110455

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн Ээлжит
IX хуралдааны 09/04 дүгээр тогтоолын хавсралт



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- | | |
|---------------|---|
| П.Пүрэвлхагва | - Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч |
| С.Ганцогт | - Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, Хотын захирагчийн албаны дарга |
| Б.Зоригтбаяр | - Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, Жаргалант сумын Засаг дарга |
| Д.Дарханбаяр | - Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч |
| Б.Цогт-Очир | - Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч |
| Ц.Эрдэнэчимэг | - Орон нутгийн өмчийн газрын өмчийн бүртгэл, хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн |
| Д.Содномжамц | - “Эрдэнэт ус, ДТС” ОНӨХК-ийн ерөнхий инженер |
| Э.Хангал | - “Эрдэнэт ус, ДТС” ОНӨХК-ийн дулааны албаны дарга |
| Ч.Буянаа | - Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн албаны дарга |